- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлт тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн албаны тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 05 дугаар сарын 04, 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07, 11 дүгээр сарын 10, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,

- Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.



Тус хорих ангийн даргын 2023 оны 01 дүгээр сарын А/13 дугаар тушаалаар хяналт, шалгалтын хэсгийн бүрэлдэхүүн болон дотоод хяналт, шалгалт хийх ажлын төлөвлөгөөг баталсан бөгөөд төлөвлөгөөний дагуу тайлант онд хоригдлын нэрийн дансны үлдэгдэл, шилэн дансны үйл ажиллагаа болон санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Мандал сум дахь ШШГХ-413 дугаар хорих ангийн санхүүгийн үйл ажиллагаанд ШШГЕГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс сар бүр шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт болон байгууллагын харилцах дансны гүйлгээнд хяналт тавьж, үүрэг чиглэл өгч ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мандал сум дахь ШШГХ-413 дугаар хорих ангийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг **аккруэл** сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус анги нь ШШГЕГ-ын даргын 2020 оны А/134 дүгээр тушаалаар баталсан "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Мандал сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс-413 дугаар хорих ангийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар

баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 228,918.1 мянган төгрөгөөр буюу 1.9 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	24,204.82	14,376.14	-9,828.68
Авлага	10,000.00	22,440.00	12,440.00
Бараа материал	425,026.26	422,076.76	-2,949.50
Үндсэн хөрөнгө	11,332,348.56	11,103,768.67	-228,579.89
<b>Нийт хөрөнгө</b>	<b>11,791,579.64</b>	<b>11,562,661.57</b>	<b>-228,918.07</b>
Өр төлбөр	63,166.91	13,431.76	-49,735.15
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	11,728,412.73	11,549,229.81	-179,182.92
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>11,791,579.64</b>	<b>11,562,661.57</b>	<b>-228,918.07</b>

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 11,103,768.7 мянган төгрөг болж, 228,579.9 мянган төгрөгөөр буурсан нь нь ТӨБЗГ-ын 2023 оны 01 дүгээр сарын А-2/33 тогтоолоор 18,450.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг балансаас балансад шилжүүлсэн, 12 дугаар сарын 817, 818, 884 дүгээр тогтоолоор 63,976.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталснаас шалтгаалсан,
- Өр төлбөр дансны үлдэгдэл 13,431.7 мянган төгрөг болж 54,113.6 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны шатахууны өглөг 30,656,8 мянган төгрөг, төслийн зээлээр авсан өвлийн хүлэмж, үхрийн фермерийн үлдэгдэл төлбөр 16,986.6 мянган төгрөгийг бүрэн төлж барагдуулсан зэргээс голлон шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,757,746.8 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 365,861.5

мянган төгрөг, нийт зарлагыг 3,123,608.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 1,055,913.5 мянган төгрөгөөр бууруулж / *нормативт зардлыг 368,939.4 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 274,576.4 мянган төгрөгөөр, цалин, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 146,049.2 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 77,809.7 мянган төгрөгөөр тус тус бууруулан баталсан голлон нөлөөлсөн байна.* / **2,067,694.8 мянган төгрөгөөр баталсан** байна. Төсвийн жилийн дундуур батлагдсан төсвийг нийт 2,590,885.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн тодотгол хийж, **4,658,579.9 мянган төгрөгөөр эцэслэн баталсан** байна. Үүнд:

- *Урсгал шилжүүлгийн зардлыг 1,371,714.0 мянган төгрөгөөр,*
- *Цалин, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 807,438.8 мянган төгрөгөөр,*
- *Нормативт зардлыг 187,861.3 мянган төгрөгөөр,*
- *Эд хогшил, урсгал засварын зардлыг 89,854.2 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн нь голлон нөлөөлсөн байна.*

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 4,364,086.9 мянган төгрөгийг улсын төсвөөс, 294,493.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр төлөвлөн, гүйцэтгэлээр улсын төсвөөс 4,364,086.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны орлогоос 263,213.7 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Туслах үйл ажиллагаанаас нийт 287,063.2 мянган төгрөг төвлөрснөөс үндсэн үйл ажиллагаанд 263,213.7 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансаар 6,862.9 мянган төгрөгийг тус тус зарцуулсан бөгөөд өвлийн хүлэмж, үхрийн фермерийн төслийн эргэн төлөгдөх зээлд 16,986.6 мянган төгрөгийг ШШГЕГ-т төвлөрүүлснээр өөрийн орлогын төлөвлөгөөг нийт 7,429.8 мянган төгрөгөөр тасалсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,626,455.5 мянган төгрөг буюу 99.3 хувьтай тайлагнагдсан байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

*/мянган төгрөгөөр/*

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	2,978,117.20	2,977,422.20	695.00	99.98
2	Туслах үйл ажиллагааны зардал	294,493.00	263,213.70	31,279.30	89.38
3	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	10,122.30	9,974.80	147.50	98.54
4	Шийдвэр гүйцэтгэлийн үйлчилгээ	2,506.00	2,506.00	-	100.00
5	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	1,373,341.40	1,373,338.80	2.60	100.00
	<b>Нийт</b>	<b>4,658,579.90</b>	<b>4,626,455.50</b>	<b>32,124.40</b>	<b>99.31</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Мандал сумын ЗДТГ-аас марш, тактикийн тэмцээнд 3,000.0 мянган төгрөг, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 6,862.9 мянган төгрөг зэрэг нийт 9,862.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд дараах худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

/ мянган төгрөгөөр /

№	Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо, хэмжээ, хүчин чадал	Батлагдсан төсөв	Гэрээний дүн	Худалдан авах ажиллагаанд мөрдөх журам / Тендер шалгаруулалтын арга
1	Хүнсний материал /Гурил, будаа-66,463.0 мянган төгрөг /	177,800.0	177,800.0	НТШ
2	Хүнсний материал /Мах, махан бүтээгдэхүүн-60,000.0 мянган төгрөг/			НТШ
3	Хүнсний материал /Хуурай хүнс-51,337.0 мянган төгрөг/			НТШ
4	Нүүрс	97,515.8	97,515.8	НТШ
5	Шатахуун, шатах тослох материал	94,289.2	94,289.2	НТШ
	<b>Нийт дүн</b>	<b>369,605.0</b>	<b>369,605.0</b>	

Хүнсний материал бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендерийг 2 удаа зохион байгуулсан боловч оролцогч ирээгүй тул тендер шалгаруулалтын аргаа өөрчилж, харьцуулалтын аргаар 4 удаа тендер зарлахад дахин оролцогч ирээгүй байна. Иймд өмнөх онд гэрээний үндсэн дээр бэлтгэн нийлүүлэлт хийсэн Уужим хараа ХХК-тай гурил, будаа нийлүүлэх, Хараа мөнгилмаа ХХК-тай мах, махан бүтээгдэхүүн нийлүүлэх, Ноцох дөл ХХК-тай хүнс, хангамжийн материал нийлүүлэх гэрээг тус тус байгуулан, худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Мандал сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс-413 дугаар хорих ангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Отгонбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Мандал сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс-413 дугаар хорих ангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/150 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,715,700.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 27,157.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Тайлант онд тус ангийн батлагдсан төсөвт материаллаг хэмжээний өөрчлөлт гарсан тул гүйцэтгэлийн үеийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 5,062,867.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар тооцон 50,628.7 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тус анги нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Ангийн данс бүртгэлд бүртгэлтэй тээврийн хэрэгслүүдийн улсын дугаарыг тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаараар сольсон,

- Дотоод үйлдвэрлэлээс алба хаагч, хоригдлын хүнсэнд нийт 42.9 тн төмс хүнсний ногоо, мал аж ахуйгаас 4.8 тн мах махан бүтээгдэхүүн 1.7 тн сүү, сүүн бүтээгдэхүүнийг үнэ төлбөргүй нийлүүлсэн,
- 51.5 тн улаан буудай хурааж, Хорих 433-р ангиар боловсруулалт хийлгэж, 26.7 тн гурилыг алба хаагч, хоригдлын хүнсэнд нийлүүлсэн,
- Зах зээлийн үнийн өсөлтөөс шалтгаалахгүйгээр бараа бүтээгдэхүүнийг гэрээний үнээр худалдан авсан гэх мэт.



#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Мандал сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс-413 дугаар хорих анги нь мэдээлбэл зохих 28 төрлийн 168 мэдээллийг хугацаанд нь, бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны 123 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус ангийн 2023 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн цахим баримтаар баталгаажуулаагүй худалдан авалтыг гүйцэтгэж, бүртгэсэн, хандив, тусламжийн орлого төвлөрүүлж, зарцуулсан, онцгой нөхцөлийн болон цолны нэмэгдлүүдийг зөрүүтэй тооцож, олгосон зэрэг 3 зөрчилд албан шаардлага, жолоочийн тооцооны хуудсыг бүрэн хөтлөөгүй гэсэн зөрчилд зөвлөмж өгснийг тайлант онд бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	3	23,208.6	3	23,208.6	100.0
Зөвлөмж	1		1		100.0
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>23,208.6</b>	<b>3</b>	<b>23,208.6</b>	<b>100.0</b>

/мянган төгрөгөөр/

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй болно.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитын явцад нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлагналтай холбоотой дараах **16,037.3** мянган төгрөгийн алдааг залруулав. Үүнд:

1. Мандал сумын Нэгдсэн эмнэлгээс үнэ төлбөргүй шилжүүлсэн 4,597.3 мянган төгрөгийн эмийг эмийн тайланд орлого авч, бүртгээгүй нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын 2.12 дахь "Хэрэв буцалтгүй тусламжийн орлогыг хөрөнгө тухайлбал, бараа материалаар хүлээж авсан бол гэрээнд заасан эсвэл зах зээлийн үнээр бүртгэнэ. Дт. Бараа материал Кт. Тусламжийн орлого" гэсэн заалтыг зөрчсөн байна.

2. Ноцох дөл ХХК-д хүнсний материалын төлбөр 6,612.8 мянган төгрөг, ХХОАТ-т 4,827.2 мянган төгрөгийг тус тус илүү шилжүүлсэн боловч авлагаар бүртгэж, тайлагнаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ": 14.4.2: "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Аудитаар нийт 45,906.1 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс 18,869.8 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 27,036.3 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

#### 5.1 Албан шаардлага

1.Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянан баталгаажуулаагүйн улмаас Ноцох дөл ХХК-иас хүнсний материал худалдан авсны төлбөрт 6,612.8 мянган төгрөг, ХХОАТ-т 4,827.2 мянган төгрөгийг тус тус илүү шилжүүлж авлага үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдах, төлбөр тооцоог урьдчилан хянах замаар өр төлбөр үүсгэхгүй ажиллах албан шаардлага хүргүүлэх.

2. Өөрийн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 7,429.8 мянган төгрөгөөр тасалсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өөрийн орлогыг тооцоо судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөж, төлөвлөсөн орлогыг бүрэн төвлөрүүлж байх албан шаардлага хүргүүлэх.

## 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 5.2.1 Төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал:

1.1 Илрүүлэлт: Төсвийн төлөвлөгөөг бодит тооцоо судалгаанд үндэслэн, эдийн засгийн ангиллаар үнэн зөв төлөвлөөгүй, төсвийн зохицуулалт хийх саналыг тухай бүр хүргүүлээгүйгээс цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлаас НДШ-ийн зардалд 2,019.1 мянган төгрөг, бараа ажил, үйлчилгээний бусад зардлаас бичиг хэргийн зардалд 2,634.0 мянган төгрөг, урсгал засварт 5,956.6 мянган төгрөг, хоолны зардалд 1,228.3 мянган төгрөг зэрэг нийт **11,838.0** мянган төгрөгийг зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална”, 5.1.2: “Төсвийн иж бүрэн, **үнэн зөв** байдлыг хангасан байх”, 42 дугаар зүйлийн 42.3.1 дэх “Төсвийн захирагч нь төсөвт зохицуулалт хийх саналаа харьяалагдах төсвийн төвлөрүүлэн захирагчид, ...хүргүүлэх”. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан гаргах үндэслэл болно” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Төсвийн төлөвлөлтийг бодит тооцоо судалгаанд үндэслэн үнэн зөв төлөвлөх, шаардлагатай тохиолдолд төсөвт зохицуулалт хийлгэж байх.

2.1 Илрүүлэлт: Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 дахь “... байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр “Ахмадын сан” байгуулах.....”, Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 2-р хавсралтаар баталсан “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ын 1.3 дахь “Төсөвт байгууллагын тухайд цалингийн сангийн 3 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр сан байгуулж, шаардагдах хөрөнгийг төсөвтөө жил бүр тусгана” гэсэн заалтын дагуу Ахмадын сангийн эх үүсвэрийг төсөвт тусган төлөвлөөгүйгээс жилийн эцэст цалингийн зардлаас **15,198.3** мянган төгрөгийг

төрийн сан дахь "Ахмадын сан"-ийн 100130412507 дугаар дансанд шилжүүлсэн байна.



Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална", 5.1.2 дахь "Төсвийн иж бүрэн, **үнэн зөв** байдлыг хангасан байх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 дахь заалтыг хэрэгжүүлэн тухайн жилийн төсвийн төлөвлөгөөнд "Ахмадын сан"-ийн зардлыг тусган, батлуулах.

Дээрх зөвлөмжүүдийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5<sup>2</sup> дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 15 - ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

<sup>2</sup> Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй		8055436	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үнэ төлбөргүй шилжин ирсэн эмийг бүртгэлд тусгаагүй	1	4,597.3	1	4,597.3			1	4,597.3				
Авлага тусгаагүй	2	11,440.0	2	11,440.0			2	11,440.0				
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>16,037.3</b>	<b>3</b>	<b>16,037.3</b>			<b>3</b>	<b>16,037.3</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төсвийг зохистой удирдаагүйгээс авлага үүсгэсэн.	1	11,440.0			1	11,440.0						
Өөрийн орлогын төлөвлөгөөг тасалсан.	1	7,429.8			1	7,429.8						
Төсвийг үнэн зөв төлөвлөөгүй	2	27,036.3					2	27,036.3				
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>45,906.1</b>			<b>2</b>	<b>18,869.8</b>	<b>2</b>	<b>27,036.3</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								

<b>Дүн</b>									
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
<b>Дүн</b>									
<b>Нийт дүн</b>									





СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 15 өдөр

Дугаар 09/А1860388

Сүхбаатар

СЭА-2024/29/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс-413 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянан баталгаажуулаагүйн улмаас Ноцох дөл ХХК-иас хүнсний материал худалдан авсны төлбөрт 6,612.8 мянган төгрөг, ХХОАТ-т 4,827.2 мянган төгрөгийг тус тус илүү шилжүүлж, авлага үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.1.11 "Хууль тогтоомж ... зөрчсөн..." гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас өр төлбөр үүсгэсэн зөрчлийг арилган, давтан гаргахгүй ажиллаж, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс-413 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн дарга, хурандаа А.Батхуяг, ахлах нягтлан бодогч, хошууч С.Өлзий-Эрдэнэ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

Ц.ОТГОНБАЯР



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 15 өдөр

Дугаар 10/А/1860388  
СЭА-2024/21/НА-СТА-ТНЗ

Сүхбаатар

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс-413 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өөрийн орлогын төлөвлөгөөг 7,429.8 мянган төгрөгөөр тасалсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.1.11 "Хууль тогтоомж ... зөрчсөн..." гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төлөвлөсөн өөрийн орлогыг бүрэн төвлөрүүлээгүй зөрчлийг арилган, давтан гаргахгүй ажиллаж, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж, ажиллахыг Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс-413 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн дарга, хурандаа А.Батхуяг, ахлах нягтлан бодогч, хошууч С.Өлзий-Эрдэнэ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

Ц.ОТГОНБАЯР